МАГАДЛАЛ - 1

1. Нэгээс мянга хүртэлх тоонуудаас таамгаар нэгийг авахад тэр нь 11-д хуваагдах тоо байх магадлалыг ол. /2007он/

   (A) $0,08$ (B) $0,12$ (C) $0,1$ (D) $0,11$ (E) $0,09$

2. Хэлбэр хэмжээгээрээ ижил 13 улаан , 13 цэнхэр бөмбөгийг тэнцүү тоотой 2 хэсэгт санамсаргүйгээр хуваахад аль нэг хэсэгт нь 12 улаан , 1 цэнхэр бөмбөг байх магадлалыг ол. /2008он/

   (A) $\frac{1}{7}$ (B) $\frac{C_{13}^{1}C_{13}^{12}}{C_{26}^{13}}$ (C) $\frac{1}{13}$ (D) $\frac{2C_{13}^{1}C_{13}^{12}}{C_{26}^{13}}$ (E) $\frac{A_{13}^{1}A_{13}^{12}}{A_{26}^{13}}$

3. Уутанд 2 хөх, 4 улаан, 2 шар алчуур байв. Уутнаас таамгаар 2 алчуур авахад ижил өнгийн алчуур таарах магадлалыг ол. /2010он/

   (A) $\frac{3}{7}$ (B) $\frac{2}{7}$ (C) $\frac{2}{5}$ (D) $\frac{1}{2}$ (E) $\frac{3}{5}$

4. 3 оронтой тоо санамсаргүй бичихэд цифрүүдийн нийлбэр нь 27 байх магадлалыг ол. /2011он/

   (A) $\frac{1}{990}$ (B) $\frac{1}{450}$ (C) $\frac{1}{999}$ (D) $\frac{1}{900}$ (E) $\frac{1}{1000}$

5. Бүх талс нь будагтай кубыг 1000 ширхэг тэнцүү кубэд хуваав. Эдгээр кубүүдээс таамгаар нэгийг сонгоход ядаж 2 талс нь будагтай куб таарах магадлалыг ол. /2012он/

   (A) $\frac{12}{125}$ (B) $\frac{13}{125}$ (C) $\frac{26}{125}$ (D) $\frac{64}{125}$ (E) $\frac{96}{125}$

6. Гар утасны дугаарын эхний 4 оронгийн цифрүүдийн нийлбэр сүүлчийн 4 оронгийн цифрүүдийн нийлбэртэй тэнцүү байвал ''аз''-тай дугаар гэе. 9994*5*9 хэлбэрийн дугаартай хэрэглэгч азтай дугаар барих магадлалыг ол. /2014он/

   (A) 0.05 (B) 0.02 (C) 0.04 (D) 0.2 (E) 0.01

7. Нэгж радиустай дугуй дотроос таамгаар нэг цэг авахад дугуйн төвөөс $\frac{1}{3}$ – ээс бага зайд байх магадлалыг ол. /2015он/

   (A) $\frac{1}{9}$ (B) $\frac{1}{2}$ (C) $\frac{1}{3}$ (D) $\frac{2}{3}$ (E) $\frac{8}{9}$

8. ''Шалгалт'' гэдэг үгнээс 2 үсэг дарахад хоёулаа гийгүүлэгч байх магадлалыг олоорой. /2016он/

   (A) $\frac{1}{3}$ (B) $\frac{10}{21}$ (C) $\frac{5}{7}$ (D) $\frac{7}{9}$ (E) $\frac{4}{5}$

9. Хайрцагт 5 улаан, 3 хөх бөмбөг байв. Хайрцагнаас таамгаар 2 бөмбөг буцааж хийхгүйгээр дараалан нэг нэгээр нь авахад эхэлж авсан бөмбөг нь улаан, дараа нь авсан бөмбөг хөх байх магадлалыг ол. /2015он/

   (A) $\frac{15}{28}$ (B) $\frac{15}{56}$ (C) $\frac{1}{15}$ (D) $\frac{15}{64}$ (E) $\frac{25}{64}$

10. Нэгээс мянга хүртэлх тоонуудаас таамгаар нэгийг авахад тэр нь 13-д хуваагдах тоо байх магадлалыг ол. /2007он/

    (A) $0,074$ (B) $0,075$ (C) $0,078$ (D) $0,077$ (E) $0,076$



LIVEWORKSHEETS